

БАТЛАВ:

БОАЖЯ ХБОБЗГ-ЫН

ДАРГА:/ ...../ Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРСӨН :

“АРГАЛ ОЙЛ” ХХК-НЫ

ЗАХИРАЛ :/...../ Д. БААСАН

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ АРГАЛ  
ОЙЛ ХХК-НИЙ ХАРЬЯА “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
АГУУЛАХ” –ЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

РД: / 6309011 /

ХЯНАСАН :

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН: /...../ Б.БАТБАЯР

ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН ГАРГАСАН :

ХАБЭА АЖИЛТАН :/...../ Ш.БИЛЭГДЭМБЭРЭЛ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

2023 ОН

Агуулга :

- Төслийн товч танилцуулга
- Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл
- Байгаль орчны тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний гол зорилт
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт
- Хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь
- Дүгнэлт

Төслийн товч танилцуулга

Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр : “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах “  
Төсөл хэрэгжүүлэгч : “Аргал ойл” ХХК  
Төслийн дугаар : 2019/Л 28  
Улсын бүртгэлийн дугаар : 901173311  
Регистерийн дугаар : 6309011  
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг Улаанбаатар хот , Сүхбаатар дүүрэг , 6-р хороо Нэгдсэн  
Үндэстний гудамж 47 байр 3 тоот

Утас : 88104901

Газар ашиглах зориулалт Газрын тосны бүтээгдэхүүний агуулах

Төслийн байршил Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ган зам багийн нутаг  
дэвсгэрт

Тус агуулах нь газрын тосны бүтээгдэхүүний хадгалах савны нийт багтаамж  $8800\text{м}^3$  үүнээс  $2000\text{м}^3$ -ийн 4 ширхэг,  $400\text{м}^3$ -ийн 2 ширхэг босоо цилиндр ган савтай





### ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ТОДОРХОЙЛОЛТ

№	Нэг. Эрх зүйн бичиг баримтууд	Бүрдэл		
1	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, эзэмших газрын хэмжээ	№ 0171588,	2012/04/27,	37930 м2
2	Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах улсын комиссын акт, огноо	2012.12.28, 02/107/2012		
3	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага	“Молонгоо” ХХК, 11/01		
4	Галын аюулгүй байдлын зөвшөөрөл	№ 0006218, 2023.10.25		
	<b>Хоёр. Техник технологийн байдал</b>	<b>Үзүүлэлтүүд</b>		
	<b>Вагон эстакад</b>			
Д/д	Бүрэлдэхүүн	Хэмжих нэгж	Хүчин чадал	
1.1	Байгууламж	Төмөр замын урт	м	610 м
		Шат тавцангийн урт	м	90м
		Гэрэлтүүлэг	ш, вт	16ш 40вт
		Газардуулга	тайлбар	8
		Ослын сав, суваг	м3,м	10м3-н 4 ш

1.2	Коллектор	Дг	Диаметр	мм	273
			Урт	м	86
		А-80	Диаметр	мм	200
			Урт	м	86
		А-92	Диаметр	мм	200
			Урт	м	86
		А-95	Диаметр	мм	200
Урт	м		86		
Шүүр, тунгаагуур			ш	4	
1.3	Ачих буулгах төхөөрөмж	Нийт тоо		ш	8
		Дээгүүр буулгах		ш	0
		Дээгүүр ачих		ш	0
		Доогуур буулгах		ш	8
		Доогуур ачих		ш	8
		Газардуулга		ш	8
<b>2</b>	<b>Автоцистернээс буулгах байгууламж</b>				
2.1	Байгууламж	Тэгш талбай, суваг		ш	-
		Ослын сав		ш	-
		Буулгах худаг		ш	-
		Шүүр тунгаагуур		ш	-
		Хаалт		ш	-
		Газардуулга		ш	-
		Гэрэлтүүлэг		ш	-
<b>3</b>	<b>Авто эстакад</b>				
3.1	Байгууламж	Саравч		ш	1
		Тэгш талбай		м <sup>2</sup>	1800 м <sup>2</sup>
		Шат, тавцан		ш, м	-
		Гэрэлтүүлэг			14
	Ачих төхөөрөмж	Нийт тоо		ш	4
		Насос		ш	4
		Хаалт		ш	8
		Шүүр тунгаагуур		ш	4
		Шингэний тоолуур		ш	4
		Газардуулга		ш	4
		Илүүдлийн сав		ш	-
		<b>4</b>	<b>Насос станц</b>		
4.1	Насос	Буулгах	тоо		4
			марк		HGBW150
			мЗц		150 мЗц
	Ачих	тоо		4	
		марк		HGBW60-6	
		мЗц		60мЗц	
4.2	Барилга	Үндсэн хийц		тайлбар	Тоосго
		Агааржуулалт		тайлбар	Агааржуулалтын нэгдсэн системтэй
		Гэрэлтүүлэг		тайлбар	Гадна 2, дотор 20
		Халаалт		тайлбар	Цахилгаанаар
<b>5</b>	<b>Сав, парк, шугам хоолой</b>				
		Үйлдвэрлэсэн улс		тайлбар	Хятад

АРГАЛ ОЙЛ ХХК-Н БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

5.1	Сав	Тоо	ш	6	
		Байрлал	тайлбар	Босоо цилиндр /РГС/	
		Нийт багтаамж	м3	8800 одоо байгаа дизел тулш	
5.2	Байгууламжууд	Далан	тайлбар	Хөрсөн дээр нь бетонон хучилттай	
		Талбай	тайлбар	Паркийг бүхэлд нь бетонон хучилттай	
		Суваг шуудуу	тайлбар	Ууршуулах талбайтай холбогдсон хоолойтой	
		Ослын сав	ш, м3	Ууршуулах талбайтай	
5.3	Технологийн шугам хоолой	Урт	А-80	м	67
			А-92	м	67
			А-95	м	67
			Дг	м	67
		Диаметр	А-80	мм	150, 200
			А-92	мм	150, 200
			А-95	мм	150, 200
			Дг	мм	150, 200
<b>6</b>	<b>Бусад байгууламжууд</b>				
6.1	Талбайн гэрэлтүүлэг	Тэсрэлтийн хамгаалалттай	ш	Вагон эстакад-16, ачих-14	
		Суурин	ш	Цамхагт гэрэл -5	
6.2	Гал унтраах багаж, тоног төхөөрөмж	Усан сан	м3	500	
		Хөөсний нөөц	м3		
		Хөргөлтийн систем	тайлбар	Хөргөлтын ус хөөсний системтэй /сав бүр/	
		Ослын дохиолол			
		Галын анхан шатны багаж хэрэгсэл		Галын сарай-5, багаж хэрэгсэл, галын хор нормын дагуу хангалттай	
6.3	Савласан ГТБ хадгалах байр	Барилга	м3	-	
		Талбай	м2	-	
6.4	Цуглуулах, ууршуулах, цэвэрлэх байгууламж		тайлбар	44x24, 11x17 хэмжээтэй пелёнкон хучилттай ууршуулах болон лагийн талбайтай	
6.5	Дохиолол, камер, харуул хамгаалалт		тайлбар	24 цагийн харуул хамгаалалттай, 17 ш камерийн хяналттай.	
6.6	Хашаа		тайлбар	Эргэн тойрон бетонон хашаатай	

### Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд дэлгэрүүлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд :

- Усан орчинд үзүүлэх нөлөөлөл
  - Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл
  - Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл
  - Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл
  - Ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
- Төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг

хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай

Оноот үнэлгээний аргачлалаар тооцов. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан судалгааны энэ арга нь нөлөөллийн үр дагаврыг тоогоор тодорхойлох боломжтой , нөлөөлөлд өртөгдсөн талбайн байгаль орчны чадамжийг энгийн аргаар зохистой төвшинд доторхойлдог

нөлөөлөл нь (I) эерэг (+) сөрөг (-) болон тодорхой бус ( 0.нөлөөгүй ) байна.

Нөлөөллийн хуримтлалын зэргийг  $I^* (A1+A2+A3+B1+B2+C1)$  томъёогоор тооцоолно

№	Байгаль орчны хүчин зүйлс	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин
		I	A1	A2	A3	B1	B2	C1		
1	Гадаргы ус	-1	1	1	1	1	2	1	-7	Бага ба нөлөөгүй
2	Газрын доорх ус	-1	2	1	2	1	2	1	-9	Дунд
3	Газрын гадарга	-1	2	2	3	2	3	3	-17	Их
4	Ургамлан нөмрөг	-1	2	2	3	1	2	3	-15	Их
5	Хөрсөн бүрхэвч	-1	2	2	3	1	3	2	-15	Их
6	Агаарын чанар	-1	2	1	2	2	2	1	-10	Дунд
7	Амьтны аймаг	-1	1	1	1	1	2	1	-7	Бага ба нөлөөгүй
8	Дуу чимээ	-1	2	1	2	2	2	1	-10	Дунд
9	Хог хаягдал	-1	2	1	2	1	2	1	-9	Дунд
10	Эрүүл мэнд	-1	2	1	2	1	2	2	-10	Дунд
11	Зам талбай	-1	1	1	1	2	2	1	-8	Бага ба нөлөөгүй
12	Түүх соёлын дурсгалт газар	0	1	1	1	1	1	1	6	Бага ба нөлөөгүй
13	Эдийн засгийн нийгмийн нөлөө	-1	2	1	2	2	2	1	-10	Дунд
14	Аваар ослын эрсдэл	-1	1	1	2	1	2	2	-9	Дунд

Төслөөс учрах гол нөлөөллүүдийн эрчмийг хувиар илэрхийлбэл бага нөлөөлөл 28,6%, дунд нөлөөлөл 50%, их нөлөөлөл 21,4% хувь байна. Бага нөлөөлөл д гадаргын ус , амьтны аймаг , зам

талбай түүх соёлын дурсгалт зүйлс , дунд нөлөөлөлд агаарын чанар , амьтны аймаг , дуу чимээ хог хаягдал , эрүүл мэнд зам талбай , эдийн засгийн нийгмийн нөлөө аваар ослын эрсдэл, их нөлөөлөлд газрын гадарга , ургамлан нөмрөг , хөрсөн бүрхэвч орсон. Барилга байгууламж барих үед газрын гадарга сүйдэж хог хаягдал бий болно. Газар шорооны ажлын үед тоос дуу чимээ үүснэ.

#### **Технологи зөрчигдсөнөөс үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл:**

Нефтийн бүтээгдэхүүн хадгалах, дамжуулах, тээвэрлэх технологи зөрчигдсөнөөс дараах сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй Үүнд:

- Амьсгалах клапаны үйл ажиллагаа доголдох юм уу гэмтсэнээс уур, агаарын холимгийн их хэмжээний агаар орчинд гаргах бохирдлын байнгын эх үүсвэр бий болгох
- Шугам хоолой болон сав хоорондын холбоосууд дээрх арматурын элэгдэл хуучралаас болж ажиллахгүй болох, гацах улмаар солиход хүрэх
- Насос дамжуулах хоолойн холбоос гэмтэж, ачих буулгах үед нефтийн бүтээгдэхүүн алдагдах
- Шингэний тоолуур, савны түвшин хэмжигч, даралт хэмжигч зэрэг хэмжилтийн багажийн ажиллагааны доголдлоос үүдэн нефтийн бүтээгдэхүүн алдагдах
- Ачих буулгах хэмжих болон бусад технологийн горимыг зөрчсөнөөс нефтийн бүтээгдэхүүн алдагдах
- Тосолгооны материал, шингэнүүдийг хадгалах, савлах технологи зөрчигдсөнөөс алдагдах
- Насосууд дээр гэмтэл гарах, буруу сав, шугам хоолой руу шахах, дамжуулах хоолой гэмтэх, даралтын горим алдагдах зэрэг технологийн зөрчлөөс үүдэн нефтийн бүтээгдэхүүн алдагдах бололцоотой.

#### **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

- Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь орон нутгийн тоосжилтын түвшин нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй, Тоосжилтын улмаас агуулахын ажилчид нутгийн иргэдийн эрүүл мэнд болон эргэн тойрны байгаль орчинд зохих хэмжээгээр нөлөөлөх учир төслийн үйл ажиллааны холбоотойгоор үүсч буй тоосжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайн агуулахын хувьд хийн хяагдал үүсэх үүсвэрүүд гэвэл шатахуун нефтийн бүтээгдэхүүний ууршилт, авто машины утаа зэрэг байхаарр байна.

#### **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл :**

- Нефтээр бохирдсон орчмын байгалын усны эрдэсжилт их өндөр байдаг. Нийт давсны агууламж 10-50-100г/л-т хүрч хлор, бари, иод зэрэг шүлтийн металлууд, бор, стронций зэрэг хүнд металлуудыг агуулна. Аүн амьтад ундны усны зорилгоор хэрэглэх боломжгүй болно.

#### **Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл :**

- Химийн хор
- Эрдэс бордоо үйлдвэрийн хаягдал
- Доторлогоогүй хийгдсэн гадаа жорлон
- Нефт нефтийн бүтээгдэхүүн юм
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олон салаа зам гаргах зэрэг хөрс эвдэрч гэмтэх сөрөг нөлөөлөл болно.

**Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:**

Тус агуулах нь зориулалтын боловч зохиомол бичил цаг уурын нөхцөл дуу шуугиан, чийглэг, тоосжилт, нүдний нарийн хараа шаардсан ажлын онцлог хортой нөхцөлд ордог

Нефтийн бүтээгдэхүүний шугам хоолой болон битүүмжлэл алдагдах

Тээвэрлэлтийн болон бусад үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчигдөх

Техникийн бүрэн бус байдал

Аюулгүй ажиллагааны дүрэм журам зөрчих зэрэг, сөрөг нөлөөлөл болно

**Байгаль орчны тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний гол зорилт :**

Тус тайлангийн агуулга бүтцийн хувьд тухайн жилийн байгаль орчны менежментийн тайлан нь төслийн үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр авч үзэх үүнд агаар, хөрс, ургамал, амьтан, болон төслийн талбайн ойролцоох нутгийн иргэд багтана. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх. Эрсдэлийн үнэлгээ, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, байгаль орчны тухайн жилийн менежментийн тайланд тусгах. Тухайн жилийн байгаль орчны менежментийн гол зорилго нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн тухайн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, хүний эрүүл мэнд байгаль орчин, эдийн засгийн үр ашигт учруулах эрсдлийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох юм.

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөсөн ажил	Хийгдсэн ажил	Нийт зардал, төг
<b>Усан орчин</b>				
	Гадаргын ус болон газар доорх усанд нефтийн бүтээгдэхүүн алдагдах	Өдөр тутмын үзлэг шалгалт сав тоног төхөөрөмжийн битүүмжлэл хаалтуудын жийрэг солих	Өдөр тутмын үзлэг шалгалт. Хаалт холбоосуудын жийрэг солих ажлууд хийгдэж нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд алдагдах тохиолдол гаргаагүй	200,000
	Агуулахын усан орчинг сайжруулж, галын усан санг усаар дүүргэж, бэлэн байдалд байлгах	Худагт өрөмдлөг хийж ундарга сэргээх ус	Байгаль орчин аялал жуулчлалын газраас худаг, ус өрөмдөх зөвшөөрөл авч Буян ус ХХК-р цооног өрөмдүүлсэн	хийгдсэн
		Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Байгаль орчны газраас ус ашиглах дүгнэлт гаргуулсан	50000
		Худагт паспорт авах бүртгэлд оруулах	Худгийг паспортжуулж бүртгэлд оруулсан	хийгдсэн
		Хаягдал усны дүгнэлт гаргуулж	Усны сав газраар хаягдал усны дүгнэлт гаргуулж сумын засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байгаа	-
		Худагт тоолуур суулгах	Шинээр тоолуур тавиулж Гэрчилгээ авсан	21010
		Усны гэрээ хийж ажиллах	Сүмбэр сумын засаг даргатай усны гэрээ хийсэн	хийгдсэн
		Нийт		



**Усны тоолуур суурилуулах үеийн акт**  
№6

2023 оны 02-р сарын 24 Говьсүмбэр

**АРГАЛ ОЙЛ ХХК танай**

**LXS6-32** маркийн **Ф32** мм-ийн голчтой хүйтэн усны **№201901249** дугаартай тоолуурыг **№000256** дугаартай лацаар лацдаж БИТҮҮ ШУГАМ ХООЛОЙ ДАХЬ УСНЫ ЗАРЦУУЛАЛТ ХЭМЖИЛТ УНДНЫ ХҮЙТЭН УС БА ХАЛУУН УСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА **MNS ISO 4064-2:2013** стандартын дагуу суурилуулсан болно. Тоолуурын хүчинтэй хугацаа 2025.02.17 өдөр хүртэл хугацаанд ашиглана. Суурилуулах үеийн заалт **01706 м3**

**Акт үйлдсэн:**  
УХАТ Инженер ..... /Ө.Наранчулуун/ тэмдэг

**Тоолуур суурилуулсан:**  
Засварчин ..... /Э.Наранмандах /

Шалгаж хүлээн авсан ..... / /

 **СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**


**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**  
№ ЭУ **065686**

.....-Д  
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа **LXS6** загварын **6** м<sup>3</sup>/ц хэмжих хязгаартай, **32** мм-ийн голчтой № **201901249** -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № **014** лацаар битүүмжилж **2023** оны **02** -р сарын **17** -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: **01706** м<sup>3</sup>

 Лабораторийн тэмдэг **2023** оны **02**-р сарын **17** -ны өдөр

 Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг



2023 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023.04.09

Дугаар 2023/01

Говьсүмбэр аймаг

- 1. Аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:**  
“Аргал Ойл” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж, 47-р байр, 3 тоот, гүйцэтгэх захирал Д.Баасан, 88124621, 88104901, улсын бүртгэлийн дугаар 9011733116, регистрийн дугаар 6309011
- 2. Төслийн нэр, байршил:** Газрын тосны бүтээгдэхүүн агуулах, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1 дүгээр баг, Үйлдвэрлэл 1 гудамж 113 тоот. /Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2019 оны 06 сарын 17-ний өдрийн А/225 тоот шийдвэр/
- 3. Төсөл хэрэгжүүлэгч:**  
“Аргал Ойл” ХХК
- 4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /Х,У/:**  
Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл, дугаар 321  
**Талбайн координат:** х 108° 36" 414'  
у 46° 34" 550'
- 5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:**  
Газрын тосны бүтээгдэхүүн агуулах, Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, хадгалах, худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- 6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:**  
Газрын тосны бүтээгдэхүүн агуулах нь Хятад улсад үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалттай 2000м<sup>3</sup> багтаамжтай 4 ширхэг босоо цилиндр савтай, 400м<sup>3</sup>-ийн 2 ширхэг савтай нийт 8800м<sup>3</sup> багтаамжтай. Нэг зэрэг 4 вагон ачих, буулгах вагон сткад, 2 автомашин зэрэг ачих авто сткадтай, шингэн бүтээгдэхүүн ачиж буулгах 160м<sup>3</sup>/ц хүчин чадалтай 4 ширхэг насос станцтай.  
23х13 хэмжээтэй оффиссын барилга, боловсон ариун цэврийн өрөө, ажилчдын цайны газартай. 2023 онд өдөрт 7 хүн 8 цагаар ажиллах бөгөөд харуул хамгаалалтын 6 ажилтан 24:48 цагаар ажиллана. Нийт 13 ажилтантай.
- 7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:**  
Газрын тосны бүтээгдэхүүн агуулах нь жилийн 365 хоног ажиллах бөгөөд сардаа 1.800.000 орчим литр шатахуун буулгаж түгээдэг.
- 8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:**  
Тус агуулах нь технологид ус хэрэглэхгүй. Ундны усны хэрэглээг усан хангамжийн худгаас зөөвөрлөн хэрэглэдэг. Ногоон байгууламж, гал унтраах болон ажилчдын ахуйн зориулалтаар газрын доорх усыг ашиглана.
- 9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:**  
Өрөмдмөл худаг 1 ширхэг, 250м<sup>3</sup> багтаамжтай 2 ширхэг галын усан сантай.
- 10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:**  
Цооногийн гүн 108 м, ундарга 0,9 л/сек. Координат: х - 108° 36" 414'  
у - 46° 34" 550'
- Ахуйн зориулалтаар ашиглах өрөмдмөл худаг, худгийн насосны марк QJD 1.5кв, LXSG маркийн ф32 мм-ийн голчтой хүйтэн усны тоолуурыг “Ус Ду” ОНӨААТҮГ-аар 2023 онд суурилуулсан.
- 11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:**  
-
- 12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:**  
Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг бохирын цооногт хуримтлуулж тохижилт үйлчилгээний газраар соруулж хаягдал ус хаях цэгт зайлуулдаг.

**13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар**

Усыг ашиглах боломжит нөөцийн хэмжээнд зохистой ашиглах.

**14. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах "Аргал Ойл" ХХК-ийн "Газрын тосны бүтээгдэхүүн агуулах" төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2020 онд "Тэкол" ХХК-иар гүйцэтгүүлж батлуулсан.

**15. Онцгой нөхцөл:**

Худгийн тоолуурын ашиглалт, чанар, баталгаажуулалтад хяналт тавьж бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах

**16. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцоход:**

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ийг үндэслэн тооцоход:

**Ногоон байгууламжийн усалгаанд:**

Оффиссын гадна талбайд тарьсан 14 ширхэг модыг сард дунджаар 5 удаа услана гэж тооцоход 7 сарын хугацаанд нийт 35 удаа услана гэж тооцов. /Тус компанийн 2023 оны ус ашиглах төлөвлөгөөг үндэслэв./

14ш x 40л/хон x 35удаа = 19.6м<sup>3</sup>/жил

**Ажилчдын ахуйн хэрэглээнд зарцуулах ус:**

8 хүн x 80л/хон x 245хон = 156.8м<sup>3</sup>/жил

**Гал унтраахад:**

Галын усан санд 500м<sup>3</sup>/жил

Нийт усны хэрэглээ: 19.6м<sup>3</sup>/жил+156.8м<sup>3</sup> жил+500м<sup>3</sup>/жил = 676.4м<sup>3</sup>/жил

**16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын дагуу түймэр унтраах, гамшигтай тэмцэх зориулалтаар ашиглах- 500м<sup>3</sup>/жил усны төлбөрийг төлбөрөөс чөлөөлнө.

Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн тооцвол:

1м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр: **3700төг/м<sup>3</sup> x 0.16 x 15%=88.8 төг**

- 3700 төг/м<sup>3</sup> – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ.

- (15%) - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ.

- (0.16) – Бусад, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усанд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

**156.8м<sup>3</sup>/жил x 88.8төг = 13923 төгрөг /арван гурван мянга есөн зуун хорин гурав/**

Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах **19.6м<sup>3</sup>/жил** усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

1м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр: **3700төг/м<sup>3</sup> x 0.15 x 0.2 = 111төг/м<sup>3</sup>**

- 3700 төг/м<sup>3</sup> – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

- (15%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 10-д заасан газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь;

- (0.2) – Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр  
 $19.6\text{м}^3/\text{жил} \times 111\text{төг}/\text{м}^3 = 2175\text{ төг}$  /Хоёр мянга нэг зуун далан тав/  
 Нийт ус ашигласны төлбөр  $13923+2175=16098$  /арван зургаан мянга ерэн найм/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Төрийн сангийн **100220000944** тоот дансанд төвлөрүүлэх.

**18. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж**

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн "Усны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах.
- Усны эх үүсвэрт суурилуулсан баталгаажсан тоолуурын заалтыг үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийг тооцох бөгөөд тухайн ондоо багтааж төлөх.
- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах.
- Мөн хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарах.
- Газрын доорхи уснаас шууд ашиглах усны хэмжээг ус хэрэглээний нормоор тооцсон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/156 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг мөрдөж ажиллах
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаагаар гаргуулж Сүмбэр сумын Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулах, төлбөрийг төлөх:
- Ус ашиглалтын тайланг дараа оны 1-р улиралд багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх. Мөн оны 12 сарын 01 ны дотор багтаан ус ашиглалтын гэрээг дүгнүүлэхийг анхааруулж байна. Оны эхэнд болон оны сүүлд тоолуурын заалтыг авч баталгаажуулах.
- Ус ашиглуулах дүгнэлт гаргахад бүрдүүлэх материалын бүрдлийг ирүүлэхдээ тухайн оны төлөвлөгөө, ус ашиглалтын тайланг албан ёсоор баталгаажуулж ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны үнэлгээ,  
 усны асуудал хариуцсан мэргэжилтэн  Н.Намуунצעэг

БАТЛАВ.  
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА ..... Л. БАТ-ЭРДЭНЭ/



БАТЛАВ.  
"АРГАЛ ОЙЛ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ  
Д. БААСАН/

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 05 сарын 22 ны өдөр

Дугаар: 02

Сүмбэр сум

**Нэг. Ерөнхий зүйл**

Ус ашиглуулагчийг төлөөлж Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Уранчимэг, Ус ашиглагчийг төлөөлж улсын бүртгэлийн дугаар: 9011733116, регистрийн дугаар: 6309011 "Аргал ойл" ХХК-ийн захирал Д.Баасан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус ашиглах зориулалт: "Аргал ойл" ХХК нь ажилчдын ахуйн хэрэглээнд болон ногоон байгууламжийн усалгаа, гал унтраах зориулалтаар усны нөөцийг ашиглана.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: Баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцох

2.3. Усны эх үүсвэр, нөөц чанар, хоногт ашиглах хэмжээ: Ногоон байгууламжийн усалгаанд 19.6м<sup>3</sup>, ажилчдын ахуйн хэрэглээнд 156.8м<sup>3</sup>, гал унтраахад 500м<sup>3</sup>, тухай жилд нийт ашиглах усны хэмжээ 676.4м<sup>3</sup>/жил. Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах өрөмдмөл 1 худаг.

2.4. Усны эх үүсвэр:

2.4.1. Байршил: Худаг 1, цооногийн гүн 108м, ундарга 0.9л/сек, худгийн солбилцол х-108°36'41", у-46° 34' 55"

2.4.2. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Худагт QJD 1.5кв маркийн насос, LXSG-32 маркийн ф32мм-ийн голчтой тоолуурыг суурилуулсан.

2.5. Хаягдал ус: Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг бохирын цооногт хуримтлуулж, тохижилт үйлчилгээний газраар соруулж хаягдал ус хаях цэгт зайлуулдаг.

2.6. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.7. Усны тоолуур: 1 тоолууртай

2.8. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

$$1\text{м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 3700\text{төг/м}^3 \times 0.16 \times 15\% = 88.8 \text{ төгрөг}$$

3700төг/м<sup>3</sup> - Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

(15%) - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ

(0.16) - Бусад ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усанд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

**156.8м<sup>3</sup>жил х 88.8төг=13923 төгрөг**

Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах 19.6м<sup>3</sup>/жил усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

**1м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр: 3700төг/м<sup>3</sup> х 0.16 х 15%= 88.8 төгрөг**

3700төг/м<sup>3</sup> - Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

(15%) - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ

(0.2) – Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтаар итгэлцүүр

**19.6м<sup>3</sup>жил х 111төг=2175 төгрөг**

Газрын доорх усыг ногоон байгууламжийн усалгаа, ажилчдын ахуйн хэрэглээний зориулалтаар ашиглах **16098 /арван зургаан мянга ерэн найм/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Төрийн сангийн 100220000944 тоот дансанд төвлөрүүлэх.**

#### Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь Усны тухай хуулийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүргийг хүлээнэ:

3.2.1. Усны тухай хуулийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх.

3.2.2. Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулна.

3.2.3. Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг Сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.4. Унд ахуйн усны шинжилгээг улиралд нэг удаа хийлгэж шинжилгээний хариуг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх.

3.2.5. Ажилчдын ундны усыг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.

3.2.6. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын болон Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.7. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.14 дэх заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.8. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол Усны тухай хуулийн 33.1.13 дахь заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Дөрөв. Бусад**

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Ус ашиглуулагч нь гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.
- 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
- 4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:  
Сүмбэр сумын Байгаль орчны  
мэргэжилтэн *Франц* М.Б.Уранчимэг/  
Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг,  
Сүмбэр сумын захиргаа  
Харилцах утас: 99569581

Ус ашиглагчийг төлөөлж:  
"Аргал ойл" ХХК-ийн ХАБЭА инженер  
..... Ш.Билэгдэмбэрэл/  
Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр  
сум, 1-р баг, Төмөр замын гармын  
баруун урд талд  
Харилцах утас: 99548521

**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ**

2023 оны 08 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар: 53

Говьсүмбэр  
Сүмбэр

**1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон  
регистрийн дугаар, цахим хаяг:**

“АРГАЛ ОЙЛ” ХХК, гүйцэтгэх захирал Д.Баасан, утас 88124621, 88104901, улсын бүртгэлийн  
дугаар: 9011733116, регистрийн дугаар: 6309011

**2. Төслийн нэр, байршил:**

Газрын тосны бүтээгдэхүүн агуулах, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, Үйлдвэрлэл  
1 гудамж 113 тоот /Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2019 оны 06-р сарын 17ны өдрийн А/225  
тоот шийдвэр/

**3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**

-

**4. Цэвэрлэгээний арга, түвшин:**

Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг бохирын цооногт хуримтлуулж тохижилт үйлчилгээний  
газраар соруулж хаягдал ус хаях цэгт зайлуулдаг.

**5. Хаягдал усны хэмжээ:** Тус компанийн хаягдал усны хэмжээг Говьсүмбэр аймгийн  
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн №2023/01  
дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр гаргасан унд, ахуйн хэрэглээнд ашиглах  $156.8 \text{ м}^3/\text{жил}$ -ийг тус  
тус үндэслэн тооцов.

**6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**

Хаягдал усны шинжилгээ хийлгүүлээгүй тул Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга  
хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Хаягдал усанд  
агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” А/816/218 тушаалаар батлагдсан  
хэмжээг үндэслэн ахуйд ажилчдын тосгон  $1.5 \text{ кг}/\text{м}^3$ -ээр тооцов.

**7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:**

Органик бодис /XXX/  $1.5 \text{ кг}/\text{м}^3 \times 156.8 \text{ м}^3/\text{жил} \times 50 \text{ төг}/\text{кг} = 11760.0$   
НИЙТ: 11760 / арван нэгэн мянга долоон зуун жаран төгрөг/

**8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж:**

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан “Ус  
ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам  
дээр тоолуур суурилуулах

- Байгаль орчин аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны  
А-28/128 дугаартай “Ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах  
цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ыг хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлан  
мэдээг Сав газрын захиргаанд ирүүлэх;


- “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015”  
стандартаас давсан бол “Усны тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019  
оны А/635 дугаар тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр  
ногдуулах журам”-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

**9.Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:**

- “Усны тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Говьсүмбэр  
аймгийн Сүмбэр сумын Засаг даргатай байгуулсан “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г  
дүгнүүлж, сунгуулах

- “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас олгосон “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг”-ийг сунгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;
- Хаягдал ус хаях цэгийн байршлыг тогтоолгож Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах;
- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээг дүгнэсэн акт, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны [Umar dgobi14@gmail.com](mailto:Umar dgobi14@gmail.com) цахим хаягаар 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**ХЯНАСАН:**

УГГ - ХДТСГЗАХИРГААНЫ ДАРГА  Б.ОТГОНСҮРЭН

**БОЛОВСРУУЛСАН:**

УГГ - ХДТСГЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН  Б.ПҮРЭВСҮРЭН



ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ  
БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 09 сарын  
16-ний өдөр

Дугаар ГСАСС-53

Сүмбэр сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Сүмбэр сумын Засаг даргын гаргасан 2023 оны 09 сарын 16-ний өдрийн ГСАСС-53 дугаартай Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас: ус ашиглуулагчийг төлөөлж Сүмбэр сум ЗДТГазрын Байгаль орчны мэргэжилтэн Б.Уранчимэг, нөгөө талаас: ус бохирдуулагчийг төлөөлж Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум 1 дүгээр багт байрлах, 6309011 тоот регистрийн дугаартай "Аргал Ойл" ХХК-ийн захирал Д.Баасан нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.
- 2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.
- 2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ноогдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.
- 2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:
  - 2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;
  - 2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;
  - 2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлсэн тайлан;

2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтад заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ноогдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ыг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглагчийг төлөөлж:

